



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 17 өдөр

Дугаар А/112

Чивгис хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.2, 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд хэрэгжих Хэнтий аймгийн Хан Хэнтий чуулгад тавилга, тоног төхөөрөмж худалдан авах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга:	Г.Лхагвахатан	Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	Н.Үнэнбат	Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн
Гишүүд:	Ж.Энхбат	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн
	Ж.Даваасүрэн	Төрийн бус байгууллагын төлөөлөл
	Д.Оюун	Төрийн бус байгууллагын төлөөлөл

2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга /Г.Лхагвахатан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Н.ГАНБЯМБА

